МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 03-ны өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

***Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай***

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 60, 64, 65 дугаар зүйлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 4 сарын 13-ны Пүрэв гаригийн 14:00 цагт “Говь” хувьцаат компанийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” гэр ресторанд хуралдуулсугай. Хурлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 3 сарын 22-ны өдрөөр тогтоож, 2017 оны 3 сарын 6-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэн, хурлын товыг 2017 оны 3 сарын 7, 3 сарын 22-ны өдрүүдэд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу олон нийтэд зарласугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2017 оны 3 сарын 10-ны өдрийн дотор брокер диллерийн компаниудад хүргүүлэхээр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралт, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлтгэх, зохион байгуулах ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 3 дугаар хавсралтаар тус тус батласугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр батласугай:

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал | Н.Сүрэнрагчаа |
| Гишүүд: | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | М.Сэлэнгэ |
| | Захиргаа хүний нөөцийн газрын захирал | Ч.Солонго |

МОНГОЛ УЛС
"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 03-ны өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

6. "Говь" хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Н.Сүрэнрагчаа-д даалгасугай.

7. Саналын хуудсаар санал авах сүүлчийн өдрийг 2017 оны 4 сарын 10-ны өдрөөр тогтоож, саналын хуудсын агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

8. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

ТУЗ-ийн ДАРГА: Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД: Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Т.ОДМАА

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны
03 дугээр сарын 03-ний өдрийн хурлын
03 -р тогтоолын 1 дугаар хавсралт

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

## “ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2016 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2015 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2016 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
3. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах

"Говь" ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны
03 дугээр сарын 03-ний өдрийн хурлын
03 -р тогтоолын 2 дугаар хавсралт

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛД БЭЛТГЭХ,

## ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Гүйцэтгэх ажлын утга | Эцсийн хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|
| **А.** | **ХУРЛЫН МАТЕРИАЛ БЭЛТГЭХ** | | |
| 1 | Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан илтгэл, холбогдох шийдвэрийн төсөл | III/3 | Д.Гэрэлмаа<br>М.Сэлэнгэ |
| 2 | Компанийн үйл ажиллагааны жилийн тайлан бэлтгэж, хэвлүүлж, тараах | III/3 | М.Сэлэнгэ |
| **Б.** | **ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ** | | |
| 1 | "Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл"-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх | III/6 | М.Сэлэнгэ |
| 2 | Хурлын зар мэдээ гаргах, хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх | III/7, III/22 | М.Сэлэнгэ |
| 3 | Хурлын танхимын бэлтгэл, зохион байгуулалт, тоног төхөөрөмжөөр хангах, хурлын хэвийн явцыг хангах | IV/13 | Ч.Солонго |
| 4 | Хурал дээр хувьцаа эзэмшигчдэд таницуулах компанийн үйл ажиллагааны талаарх танилцуулга бэлдэх | IV/7 | М.Сэлэнгэ |
| 5 | Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх компанийн талаарх видео, үзүүлэн бэлдэх | IV/7 | Г.Пэлжидмаа |
| 6 | Хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд үзүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээнд гарсан дэвшилттэй талыг харуулсан загварын шоуг бэлдэх | IV/10 | Б.Болормаа<br>Ц.Будхүү |
| 7 | Саналын хуудсыг хэвлүүлэх | III/6 | М.Сэлэнгэ |
| 8 | Хурлын протокол хөтлөх ажлын хэсгийг байгуулж, бэлтгэл хангуулах | IV/11 | Ч.Солонго |

"Говь" ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны
03 дугээр сарын 03-ний өдрийн хурлын
03 -р тогтоолын 3. дугаар хавсралт

"ГОВЬ"
ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ
ТТН2998 2076357

**ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА**

1. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2017 оны 3 сарын 10-ны өдрөөс эхлэн 4 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00-17:00 цагийн хооронд "Говь" ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

2. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

   a. Компанийн санхүүгийн жилийн тайлан
   b. Санхүүгийн жилийн тайлангийн талаархи аудитын байгууллагын дүгнэлт
   c. Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт
   d. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
   e. ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
   f. Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
   g. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга

"Говь" ХК-ийн ТУЗ-ийн ..2017.. оны ..03.. дугээр сарын ..02..-ний өдрийн хурлын ..03..-р тогтоолын ..4.. дугаар хавсралт

"ГОВЬ" ХК
ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТН2998 2076357

GOBI
MONGOLIAN CASHMERE

## "ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

***Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 сарын 13-ны өдрийн 14:00 цагт Говь ХК-ийн дэргэдэх "Мираж" гэр ресторанд болно.***

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр ……………………………………………

Эзэмшиж буй хувьцааны тоо ……………………… төрөл …… *энгийн* ……

Дансны дугаар ……………………… Регистрийн дугаар ……………………

| Батлах асуудлууд: | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|
| 1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах */Саналыг энгийн аргаар тоолно/* | | | |
| ***Дүгнэлт: Өөрсдийн нөөц боломжоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан*** | ☐ | ☐ | ☐ |

| 2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батламжлах */Саналыг кумулятив аргаар тоолно./* | |
|---|---|
| ***Санал: ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгоё*** | **Нэр дэвшигчид өгөх кумулятив саналын тоо** |
| 1. Мягмарын БАЯР | ☐ |
| 2. Дамбын ГЭРЭЛМАА | ☐ |
| 3. Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ | ☐ |
| 4. Түнрэвийн ОДМАА | ☐ |
| 5. Такэши КАМБЭ | ☐ |
| | |
| ***Санал: ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгоё*** | **Нэр дэвшигчид өгөх кумулятив саналын тоо** |
| 1. Цагаачийн БААТАРСАЙХАН | ☐ |
| 2. Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ | ☐ |
| 3. Хидэо САВАДА | ☐ |
| 4. Дашдаваагийн ХУЛАН | ☐ |

2017 оны … -р сарын … -ны өдөр

Гарын үсэг ………………………………

*"Говь" ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны ... сарын ... -ны өдрийн хурлын -р тогтоолын ... дүгээр хавсралт*

GOBI
MONGOLIAN CASHMERE

## САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Саналын хуудсыг дараах зааварын дагуу бөглөнө.

- Саналыг энгийн аргаар тоолох асуудлын хувьд саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина. Жишээ нь: зөвшөөрсөн бол зөвшөөрсөн гэсэн нүдэнд (✓), татгалзсан бол татгалзсан гэсэн нүдэнд (✓), түдгэлзсэн бол түдгэлзсэн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
- Засварласан, балласан, (✓)-ээс өөр тэмдэглэгээ хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
- ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар санал хураах бөгөөд хувьцааны нэгж тутамд ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох 6, ердийн гишүүнийг сонгох 3 саналын эрх байна. Энэхүү саналын эрхээ хараат бус болон ердийн нэг нэр дэвшигчид бүгдийг нь эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх боломжтой.

2. Хэрэв та саналын хуудсаар саналаа өгөх бол хурлын материалтай танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, зуучлагч үнэт цаасны компанидаа хүргэх эсвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК хаягаар 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

3. Хэрэв та саналаа өөр хүнээр төлөөлүүлэн өгөх бол доорх мэдээллийг бөглөн, гарын үсэг зурж, өөрийн иргэний үнэмлэх эсвэл итгэмжлэх бичгийг хувьцаа эзэмшиж буйг батлах бичиг баримтын хамт өгч ирүүлнэ үү.

Таныг төлөөлөх хүний:

Овог ……………………………… нэр ……………………………...

Таны:

Овог ……………………………… нэр ……………………………...

Утасны дугаар ……………………………………………………...

Гарын үсэг ………………………………………........

“Говь” ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны
03 дүгээр сарын 03-ний өдрийн хурлын
03-р тогтоолын 5 дугаар хавсралт

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

## “ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Говь” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4 сарын 13-ны өдрийн 14 цагт “Говь” хувьцаат компанийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” гэр ресторанд болох тул хувьцаа эзэмшигчдийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2017 оны 3 сарын 22-ны өдөр

## ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн 2016 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. 2015 оны ногдол ашиг тараалтын тайлан, 2016 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах
3. ТУЗ-н гишүүнд нэр дэвшигчдийг батлах

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2017 оны 3 сарын 10-ны өдрөөс эхлэн өөрийн харилцаж буй брокер дилерийн компани дээрээ болон ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “Говь” ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ирж танилцаж болно.

Саналын хуудсаар урьдчилан санал өгөх хүмүүс харилцдаг брокер, дилерийн компани дээрээ очиж хурлын материалтай танилцан, саналын хуудсаа бөглөж, брокер дилерийн компанидаа эсвэл **Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, Говь ХК** хаягаар 2017 оны 4 сарын 10-ны өдрөөс өмнө ирүүлнэ үү.

**Холбоо барих:**

| | |
|---|---|
| Хурал зохион байгуулах комиссын дарга | Н.Сүрэнрагчаа |
| | Утас: 7013-9977(1002) |
| Гишүүд: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | М.Сэлэнгэ |
| | Утас: 7013-9977(1193), 9411-8277 |
| | И-мэйл: selenge.m@gobi.mn |

**“Говь” ХК-ийн албан ёсны хаяг, байршил:**

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,
Үйлдвэрийн гудамж, “Говь” ХК
Утас: 7013-9977, Факс: 7014-3081

**МОНГОЛ УЛС**
**“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 03-ны өдөр — Дугаар 04 — Улаанбаатар хот

***Тооллогын комисс томилох тухай***

Говь хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь хувьцаат компанийн 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

| | |
|---|---|
| Комиссын дарга: | Ч.Солонго – Захиргаа, хүний нөөцийн газрын захирал |
| Нарийн бичгийн дарга: | М.Болортуяа – Үйлдвэрлэл төлөвлөлтийн хэлтсийн дарга |
| Гишүүд: | Г.Золзаяа – Нягтлан бодогч |
| | Б.Уянга – Хүний нөөцийн менежер |
| | П.Төгсжаргал - Мэдээлэл технологийн инженер |

2. Тооллогын комисс (Ч.Солонго)-д даалгах нь:
   a. хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
   b. хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
   c. хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултанд тайлбар өгөх;
   d. санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
   e. саналын хуудсыг хайрцагаар авах;
   f. саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
   g. саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

| | |
|---|---|
| ТУЗ-ийн ДАРГА: | Д.ГЭРЭЛМАА |
| ТУЗ-ийн ГИШҮҮД: | Ц.БААТАРСАЙХАН |
| | М.БАЯР |
| | Б.НАНДИН-ЭРДЭНЭ |
| | Т.ОДМАА |
| | Ж.ОЮУНЧИМЭГ |
| | ТАКЭШИ КАМБЭ |
| | ХИДЭО САВАДА |
| | Д.ХУЛАН |

MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 03-ны өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот

***Редакцийн комисс томилох тухай***

Говь хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Говь хувьцаат компанийн 2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын редакцийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

   Комиссын дарга: Ц.Цасчихэр – Говь ХК-ийн хуулийн зөвлөх
   Гишүүд: М.Сэлэнгэ – Говь ХК-ийн ТУЗ-ын нарийн бичгийн дарга

2. Редакцийн комисс (Ц.Цасчихэр)-т даалгах нь:
   a. Хурлаас гарах шийдвэрийн төсөлд хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг тусган найруулах;
   b. Хурлаас гарах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар мэдээлж батлуулах.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

ТУЗ-ийн ДАРГА: Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ийн ГИШҮҮД: Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Т.ОДМАА

Ж.ОЮУНЧИМЭГ

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

## ТООЛЛОГЫН ДҮН

**ИРЦИЙН МЭДЭЭ:**

| | |
|---|---|
| Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн тоо | 88 |
| Хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийн тоо | 6,688,649 |
| Ирцийн хувь | 85.74% |

| № | САНАЛ ХУРААЛТ: | Саналын хуудасны тоо | Саналын эрхийн тоо | Саналын эрхийн хувь |
|---|---|---|---|---|
| **1** | **Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт батлах** | | | |
| | Саналын хуудсаа ирүүлээгүй | 11 | 545 | 0.01% |
| | Хүчинтэй саналын хуудас | 67 | 6,686,667 | 85.71% |
| | Хүчингүй болсон саналын хуудас | 10 | 1,437 | 0.02% |
| **2** | **ТУЗ-ийн гишүүдийг сонгох** | | | |
| | Саналын хуудсаа ирүүлээгүй | 11 | 545 | 0.01% |
| | Хүчинтэй саналын хуудас | 38 | 6,686,228 | 85.71% |
| | Хүчингүй болсон саналын хуудас | 39 | 1,876 | 0.02% |
| | **Нийт** | **88** | **6,688,649** | **85.74%** |

| № | Хэлэлцсэн асуудлууд | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт батлах | 99.998% | 0.000% | 0.002% |
| 2 | ТУЗ-ийн гишүүдийг сонгох | | Дэмжсэн кумулятив саналын тоо | Хувь |
| | **2.1 ТУЗ-ийн хараат бус гишүүд** | | **33,431,140** | **100.000%** |
| 1 | М.Баяр | | 6,684,204 | 19.994% |
| 2 | Д.Гэрэлмаа | | 6,689,291 | 20.009% |
| 3 | Б.Нандин-Эрдэнэ | | 6,689,036 | 20.008% |
| 4 | Т.Одмаа | | 6,684,118 | 19.994% |
| 5 | Такэши Камбэ | | 6,684,491 | 19.995% |
| | **2.2 ТУЗ-ийн ердийн гишүүд** | | **26,744,912** | **100.000%** |
| 1 | Ц.Баатарсайхан | | 6,690,173 | 25.015% |
| 2 | Ж.Оюунчимэг | | 6,684,128 | 24.992% |
| 3 | Хидэо Савада | | 6,684,455 | 24.993% |
| 4 | Д.Хулан | | 6,686,156 | 25.000% |

| | |
|---|---|
| Тооллогын комиссын дарга | Ч.СОЛОНГО |
| Нарийн бичгийн дарга | М.БОЛОРТУЯА |
| Гишүүд | Г.ЗОЛЗАЯА |
| | Б.УЯНГА |
| | П.ТӨГСЖАРГАЛ |

GOBI

MONGOLIAN CASHMERE

# ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2017 оны 04 сарын 13 өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

*Санал хураалтын нэгтгэсэн дүнгийн тухай*

МУ-ын Компанийн тухай хуулийн 67.3, СЗХ-ны "Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам", Говь ХК-ийн дүрмийн 6.10-6.16 заалтыг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

***Нэг.*** Санал хураах хайрцгаар ***85.73*** хувийн саналын эрхтэй ***6,688,104*** ширхэг хувьцааны ***77*** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.

***Хоёр.*** Брокерийн пүүсүүдээр дамжуулж ирүүлсэн санал ***0*** байсныг дурьдсугай.

***Гурав.*** Говь хувьцаат компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу ***99.99*** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

***Дөрөв.*** Говь хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудлаар хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг кумулятив аргаар тоолж, хамгийн олон санал авсан гишүүдийг баталсныг мэдэгдсүгэй.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА Ч.СОЛОНГО

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА М.БОЛОРТУЯА

ГИШҮҮД Г.ЗОЛЗАЯА

Б.УЯНГА

П.ТӨГСЖАРГАЛ

Хан-Уул дүүргийн 3-р хороо, 17062, Үйлдвэрийн гудамж-52, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-11-342713, Факс: 976-11-343081, Вэб: www.gobi.mn

GOBI

MONGOLIAN CASHMERE

# ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
# ТОГТООЛ

2017 оны 04 сарын 13 өдөр　　　Дугаар 01　　　Улаанбаатар хот

*Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон Говь хувьцаат компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр, 2017 оны 04 сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

Нэг. Говь хувьцаат компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

"ГОВЬ" ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

**ХУРЛЫН ДАРГА　　　Д.ГЭРЭЛМАА**

Хан-Уул дүүргийн 3-р хороо, 17062, Үйлдвэрийн гудамж-52, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-11-342713, Факс: 976-11-343081, Вэб: www.gobi.mn

**MONGOLIAN CASHMERE**

# ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ
# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
# ТОГТООЛ

2017 оны 04 сарын 13 өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг батлах тухай*

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1, 77.4 дэх заалтууд, Компанийн дүрмийн 6.1.9.8, 6.2.3 дахь заалтуудыг удирдлага болгон, 2017 оны 04 сарын 13-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

***Нэг.*** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.

***Хоёр.*** Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Мягмарын БАЯР

Дамбын ГЭРЭЛМАА

Банзрагчийн НАНДИН-ЭРДЭНЭ

Түнрэвийн ОДМАА

Такэши КАМБЭ нарыг;

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр:

Цагаачийн БААТАРСАЙХАН

Жавзандолгорын ОЮУНЧИМЭГ

Хидэо САВАДА

Дашдаваагийн ХУЛАН нарыг тус тус 3 жилийн хугацаагаар сонгосугай.

ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТН2998 2076357

**ХУРЛЫН ДАРГА** **Д.ГЭРЭЛМАА**

Хан-Уул дүүргийн 3-р хороо, 17062, Үйлдвэрийн гудамж-52, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 976-11-342713, Факс: 976-11-343081, Вэб: www.gobi.mn